АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас Төв аймгийн Засаг дарга **Д.Баярбат** нөгөө талаас . **Статистикийн** хэлтсийн дарга /цаашид дарга гэх/ **Жүгдэр** овогтой **Отгончулуун** нар нь Монгол улсын Үндсэн хуулийн 60.1, 61.1, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 8.1, 8.2, 26.1, 29.1, 29.1.6.л, 30.1, 39.1, 39.2, 40.2, 40.3-р заалтууд, Төрийн албаны тухай хуулийн 11.4, 11.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын ажлын хариуцлага, сахилга дэг журмыг сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, аймгийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс 2015 оны 04 сарын 18–ний өдөр харилцан тохиролцож, дараах нөхцлөөр байгуулав.

Нэг: Гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг

Талууд Монгол улсын “ЗЗНДНТУ тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль” болон Монгол улсын бусад хууль, тогтоомжид заасан эрх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд эдгээрээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ.

1.1. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

2.1.1. Хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх,үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд захиргааны удирдлагаар хангах, мэдээ мэдээллээр хангах, семинар сургалтанд хамруулах

2.1.2. Монгол улсын хууль, тухайн жилийн үр дүнгийн гэрээ, дээд байгууллагын тогтоол шийдвэр, дүрэм журам, төсөл хөтөлбөр болон тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн үүрэг даалгавар, ажил үүргийн хүрээнд баталсан төсөл хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журамд заасны дагуу тогтоосон хугацаанд нь бодитой, шударга дүгнэх, үүрэг чиглэл өгөх, хянах, шалгах

2.1.3. Үр бүтээлтэй ажилласан тохиолдолд бодлогын хэлтсийн дүгнэлт, саналыг үндэслэн зохих журмын дагуу шагнал урамшуулал олгох, төрийн дээд шагналд тодорхойлох

2.1.4. Ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаалын талаар тодорхойлолт гаргаж өгөх.

2.1.5. хууль тогтоомжинд заасан бусад үүрэг

2.2. Аймгийн Засаг даргын эрх:

2.2.1. Хууль тогтоомж, үр дүнгийн гэрээ болон байгууллагын дүрэмд заасан чиг үүрэг болон хөдөлмөрийн дотоод журам, энэхүү гэрээг биелүүлэх, захиргааны болон сахилгын зөрчил гаргахгүй байхыг шаардах, үүрэг чиглэл өгөх, шалгах, дүгнэх

2.2.2. Хувийн болон мэргэжлийн авъяас чадварыг харгалзан нийтийн ашиг сонирхлын үүднээс аймаг, сум байгууллагын зарим үйл ажиллагаанд татан оролцуулах, зохих үр дүнг тооцох

2.2.3. Аймгийн төрийн ажлын уялдаа холбоо, зохион байгуулалтыг хангах үүднээс ээлжийн амралтын эхлэх, дуусах хугацааг тогтоох, зарим тохиолдолд гадаад, дотоод албан томилолтоор ажиллуулах, дүгнэх

2.2.4. Хууль, тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах, хуульд заасан журмаар ажлаас түр болон бүр чөлөөлөх талаар томилсон эрх бүхий албан тушаалтанд санал дүгнэлтээ хүргүүлэх

2.2.5. Үр дүнгийн гэрээний биелэлтийг тогтоосон хугацаанд дүгнэж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу урамшуулах, шагнах, цалин, нэмэгдэл олгох болон сахилгын арга хэмжээ авах эсэх асуудлыг холбогдох салбарын дээд байгууллагад тавих

2.2.6. хууль тогтоомжинд заасан бусад эрх

2.3. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг:

2.3.1. Үндсэн үүрэг: байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль, тогтоомжууд болон байгууллагын дүрмийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх

2.3.2. Ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүрэг болон Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хууль тогтоомжид нийцүүлэн хариуцлагатай чанартай, хэрэгжүүлэх

2.3.3. Монгол улсын хууль тогтоомж, тухайн салбарт хэрэгжиж буй дүрэм, журам, төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангах, хяналт тавих, тайлагнах, эдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр дээд байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх

2.3.4. Монгол улсын хууль, "Хөдөлмөрийн тухай хууль" Байгууллагын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам", бусад хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэхүү гэрээг сахин биелүүлэх

2.3.5.Аймгийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, байгууллагын үйл ажиллагааны талаарх аймагт хамааралтай мэдээ мэдээлэл, ажлын тайланг Засаг даргад тогтмол тайлагнах, шаардлагатай тохиолдолд аймгийн нутаг дэвсгэрт, нийтэд хамааралтай зарим шийдвэр гаргахдаа зөвшилцөх, аймгийн ИТХ, Засаг даргаар шийдвэр гаргуулахдаа бодлогын хэлтэстэйгээ урьдчилан зөвшилцсөн байх, хууль зүйн үндэслэлийг хянуулсан байх

2.3.6. Засгийн газрын 2010 оны 288-р тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдөж ажиллах

2.3.7. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг дагаж мөрдөх, ажлын цагийг баримтлах, /долоо хоногт 40 цаг, горим: өглөө 9.00-18.00, цайны завсарлага 13.00-14.00 цаг байна./

2.3.8.Хууль, журам зөрчиж байгууллагын, орон нутгийн өмчид болон төсөвт хохирол учруулсан, хууль бус шийдвэр гаргаснаас эд хөрөнгийн шинжтэй хохирол учруулсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

2.3.9. Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан, өр авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагынхаа санхүүгийн тайланг хянаж, дүн шинжилгээ хийх, байгууллагын өмч хөрөнгийг зөв зохистой ашиглах, хамгаалах

2.3.10. Ажиллагсадыг хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, хяналт тавих, үүрэг чиглэл өгөх, шалгах, үр дүнг тооцох, дүгнэх, хариуцлага тооцох, урамшуулах зэрэг удирдлага зохион байгуулалтын бүх талын арга хэмжээг авах

2.3.11. Төрийн албаны хууль журам стандартыг хэрэгжүүлэх, зөрчил гаргахгүй байх

2.3.12.Төрийн удирдах албан хаагчийн хувьд төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, хууль, дүрэм журам, дотоод журмаа зөрчихгүй байх

2.3.13. Улс, аймаг, сумаас нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа цаг үеийн болон нийтийг хамарсан ажилд идэвхи санаачлагатай оролцох, энэ талаар аймаг сумын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх

2.3.14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг байгууллагынхаа орчинд аюулгүй ажиллах, амьдрах, сурах, төрийн үйлчилгээ авах зэрэг бүхий л нөхцлийг бүрдүүлэх, холбогдох бүх хууль, тогтоол, шийдвэр, заавар журмыг ажиллагсад үйлчлүүлэгчид иргэдийн дунд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих

2.3.15.Байгууллагын санхүүгийн, материалын болон хүний нөөцийг оновчтой зохион байгуулах, удирдах, хяналт тавих

2.3.16. Засаг даргатай Үр дүнгийн гэрээг жил бүрийн эхний улиралд багтаан байгуулсан байх, гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр хугацаанд нь бичгээр тайлагнах

2.3.17. Хууль тогтоомж, гэрээ зөрчигдсөн, байгууллагын орчинд болон үйл ажиллагаатай холбогдуулан ажилтнууд болон үйлчлүүлэгчид иргэдийн аюулгүй байдлын талаар ноцтой зөрчил гарсан, эрүүл мэндийн байдал болон бусад гачигдал гарсан, албан ажлаар ажлын байрандаа удаан хугацаагаар байхгүй байх /*7-оос дээш хоног*/, албан ажлаар гадаад, дотоод томилолт, сургалт, семинар, аялал зэрэгт явах тохиолдолд аймгийн төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо зохион байгуулалтыг хангах, салбарын чиглэлээр мэдээлэлтэй байх үүднээс тухай бүрд нь Засаг даргад мэдэгдэх

2.3.18. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ, мэдээллийг хугацаанд нь гаргаж, аймгийн ЗДТГ, бодлогын хэлтэст албан бичгээр ирүүлж байх

2.3.19. Гэмт хэрэг, архидан согтуурах, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр, үр дүнтэй зохион байгуулах

2.3.20. Албаны машин техник, байгууллагын өмч хөрөнгө, мэдээ мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, зөвхөн албаны зориулалтаар ашиглах

2.3.21. Ажиллагсадын дунд ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хяналт тавих, хариуцлага тооцох

2.3.22. Аймгийн удирдлага болон төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэд, үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллах, байнгын харилцаа холбоотой байх, мэдээд мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог хангах

2.3.23. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах

2.3.24. Төрийн албаны тухай хуулийн 10.6-д зааснаар төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байж төвийг сахих, намын гишүүнээсээ түдгэлзэх, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т зааснаар аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвших, сонгуульд оролцохоор шийдсэн бол хуульд заасан хугацаанд төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх */энэ заалт нь улс төрийн албан тушаалтанд хамаарахгүй./*

2.3.25. Төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа төрийн ажлыг улс төрийн аливаа нам хөдөлгөөний үйл ажиллагаатай хутгалдуулахгүй байх, төрийн албан хаагчид, иргэдийг улс төрийн үзэл бодлоор ялгаварлах, дарамт шахалт үзүүлэх, хууль бус шаардлага тавих зэргээр хууль зөрчихгүй байх

2.3.26. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөж хэрэгжүүлж байгаа Төрийн байгууллагуудын интернэтийн нэгдсэн сүлжээ болох Дотоод удирдлагын системийг ашиглах, байгууллагын вэб хуудсанд тавибал зохих мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулах, баяжуулах

2.3.27. хууль тогтоомжинд заасан бусад үүрэг

2.4. Төсвийн шууд захирагчийн эрх:

2.4.1.Хөдөлмөрийн хэвийн нөхцөл, ажлын байраар хангуулах, ажил үүрэгтэйгээ холбогдсон хүсэлт тавих, байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон санал хүсэлт гаргах, дэмжлэг хүсэх, шийдвэрлүүлэх

2.4.2.Хууль, тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн дагуу шагнал урамшууллыг авах, сургалтанд хамрагдах болон бусад дэмжлэг туслалцаа авах

2.4.3.Хууль тогтоомжид заасан бусад эрх

Гурав: Чөлөө зөвшөөрөл

3.1. Хуульд заасан тохиолдолд хуулиар зөвшөөрсөн хугацаагаар ажлын байраа удаан хугацаагаар */1 сараас дээш хугацаагаар/* орхих болон ажлаас түр чөлөөлөгдөх тохиолдолд аймгийн Засаг даргад *ажлын 5 хоногоос* доошгүй хугацааны өмнө урьдчилан мэдэгдэж, албан ажлаа зохицуулна. 3-аас дээш өдрийн томилолт, бусад арга хэмжээнд явахдаа бодлогын хэлтэстээ мэдэгдэнэ.

Дөрөв: Хариуцлага

4.1. Хууль, журам болон ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 11.4, 11.5, 23, 25, 26 дугаар зүйл, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 40.1.4, 40.1.5, 131, 132, 133, 135 дугаар зүйлд тус тус заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

4.2. Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 болон “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т зааснаар ажил олгогчид “***хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах”*** санал хүргүүлэх ***ноцтой зөрчил*** гэдэгт:

4.2.1.Ажлын байранд, ажлын цагаар, албан үүргээ гүйцэтгэх үедээ архидан согтуурсан нь тогтоогдсон

4.2.2.Ажил таслах, /эрх бүхий албан тушаалтнаас зохих журмын дагуу чөлөө авалгүйгээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын байраа ажлын 3 өдрөөс дээш хугацаагаар орхисон, ажил тасалсан бол/,

4.2.3.Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бөгөөд уг зөрчил нь “**ажлаас халах**”-аар хуульд заасан бол

4.2.4. “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн зөрчлийг давтан гаргасан эсвэл ноцтой зөрчсөн

4.2.5.Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хагас бүтэн жилийн дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээ авсан /60 –аас доош оноотой /

4.2.6.Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил дутагдлыг гаргахдаа *их хэмжээний зөрчил* гаргасан нь аймгийн санхүүгийн хяналт, төрийн аудит, Мэргэжлийн хяналтын газар, хууль хяналтын байгууллагын шалгалтаар тогтоогдсон бол

4.2.7.Хэрэгжүүлбэл зохих хууль журам, дүрмийг хэрэгжүүлээгүй, мөрдөөгүй, удирдан зохион байгуулаагүйгээс шалтгаалан хүний амь нас хохирох, хүнд гэмтэл учрах зэрэг ноцтой хор уршиг учирч, ажлын хариуцлага алдсан бол */Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, журам зөрчигдөж хүн осол гэмтэлд өртөх, замын хөдөлгөөний журам зөрчиж хүн осол гэмтэлд өртөх, галын аюулгүй байдал алдагдсанаас их хэмжээний хохирол учрах, хүн гэмтэл, осолд өртөх, харуул хамгаалалтын журам зөрчсөнөөс хүн гэмт хэрэг, осол гэмтэлд өртөх, байгууллагын хөрөнгө ноцтой сүйрэх, албаны нууц мэдээлэл алдагдах гэх мэт/*

4.2.8. Төрийн албаны тухай хуулийн 10.6-д заасныг зөрчиж, албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцох, намын гишүүнээсээ түдгэлзээгүй байх, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т зааснаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргалгүйгээр аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшсэн, сонгуульд оролцсон, сонгогдсон бол */энэ заалт нь улс төрийн албан тушаалтанд хамаарахгүй./*

4.2.9. НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 10-аас 22 дугаар зүйлд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн бол

4.2.10. Гэмт хэрэгт холбогдон гэм буруутай нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон

4.2.11.Албаны машин, тоног төхөөрөмж, эд хогшил, мэдээ, мэдээллийг албаны зориулалтаас гадуур, хувийн болон бусад албаны бус зорилгод ашигласан бол

4.2.12. хуулиар хориглосон бусад зөрчил, эрхээ хэтрүүлсэн, үүргээ биелүүлээгүй зэрэг ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон бол

4.3. Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 23, 25.1, 26.1.3, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.4, 40.1.5-д заасан хөдөлмөрийн харилцааг зогсоох “**үүрэгт ажлаас халах”** сахилгын шийтгэл ноогдуулах саналыг дээд шатны албан тушаалтанд хүргүүлэх зөрчилд дараахь зөрчлийг хамааруулна. Үүнд:

4.3.1.Аймгийн Засаг даргаас хууль журмын хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа /2 ба түүнээс дээш удаа/ биелүүлээгүй эсвэл хангалтгүй биелүүлсэн, эсвэл албан үүргээ хэрэгжүүлээгүй, ажлын хариуцлага алдсан зөрчлийг давтан гаргасан нь тогтоогдсон, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний улирал, жилийн дүгнэлтээр “Дутагдалтай” үнэлгээг удаа дараа авсан /70 –аас доош оноотой/ бол

4.3.2. Сахилгын зөрчил давтан гаргаж */2 ба түүнээс дээш удаа/* сахилгын арга хэмжээ авагдсан, эсвэл аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулга авсан бол

4.3.3. Удаа дараа аймгийн Засаг даргад болон бодлогын хэлтэстээ мэдэгдэлгүйгээр 7-оос дээш хоногоор гадаад дотоодод томилолтоор явах, суралцах, амрах, аялах, семинар сургалтанд явах зэргээр зөвшөөрөлгүй явсан тохиолдолд

4.3.4. Төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа төрийн ажлыг улс төрийн аливаа нам хөдөлгөөний үйл ажиллагаатай хутгалдуулсан, төрийн албан хаагчид, иргэдийг улс төрийн үзэл бодлоор ялгаварлах, дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх, хууль бус шаардлага тавих, зодолдох, биед нь халдах зэрэг төрийн албаны нэр хүндийг гутаасан ноцтой зөрчил */эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй/* гаргасан нь тогтоогдож, захиргааны хариуцлага хүлээсэн, хүлээгээгүй аль аль тохиолдолд

4.3.5. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил дутагдлыг 2 ба түүнээс дээш удаа гаргасан нь аймгийн санхүүгийн хяналт, төрийн аудит, Мэргэжлийн хяналтын газар, хууль хяналтын байгууллагын шалгалтаар тогтоогдсон бол

4.3.6. Төрийн удирдах албан тушаалтны манлайллыг зөрчиж, төрийн албаны нэр хүндийг унагаан нийгмийн хэв журам болон захиргааны журам тогтоосон хууль, журам зөрчиж эрх бүхий байгууллагын шийдвэрээр удаа дараа захиргааны арга хэмжээ авагдсан бол /баривчлагдсан, эрүүлжигдсэн гэх мэт/

4.3.7. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөж хэрэгжүүлж байгаа Төрийн байгууллагуудын интернэтийн нэгдсэн сүлжээ болох Дотоод удирдлагын системийг ашиглаагүй, байгууллагын вэб хуудсанд тавибал зохих мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулаагүй, баяжуулаагүй зөрчлийг давтан гаргасан бол

4.3.8. Аймгийн ИТХ болон Засаг даргын зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр оруулах, шийдвэрийн төсөл боловсруулан аймгийн Засаг даргаар шийдвэр гаргуулах, шаардлагатай зарим тохиолдолд төрийн дээд шатны байгууллагуудтай харилцахдаа */албан бичиг тоот явуулах, тайлан, илтгэл, мэдээлэл, судалгаа, санал зэргийг хүргүүлэх гэх мэт/* тухайн асуудлыг хариуцсан бодлогын хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж зөвшилцөөгүй, Хуульзүйн хэлтэст хууль зүйн үндэслэлийг хянуулаагүй зэрэг зөрчлийг давтан гаргасан бол

4.3.9.Удаа дараа авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон

4.3.10. хуульд заасан бусад тохиолдлууд

Тав: Гэрээг дүгнэх

5.1. Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг дарга дүгнэхээр шийдвэрлэсэн тохиолдолд гэрээний хэрэгжилтийг бичгээр гарган бодлогын хэлтэстээ хугацаанд нь ирүүлэх бөгөөд гэрээний биелэлтийг хамтран дүгнэнэ.

Зургаа: Бусад зүйл

6.1. Гэрээг хуульд заасан үндэслэл журмаар цуцлах болон дуусгавар болгоно.

6.2. Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд бичгээр үйлдэж гэрээнд хавсаргана.

6.3. Энэ гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.4. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

6.5. Гэрээтэй холбогдсон маргааныг хоёр тал зөвшилцөн шийдвэрлэхийг эрхэмлэх ба харилцан тохиролцож чадахгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төв аймгийн Засаг дарга

...../Д.Баярбат/

Төв аймгийн Статистикийн хэлтсийн дарга

...../Ж.Отгончулуун/

Огноо: 2015.04.18

ГЭРЭЭНД ОРСОН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ:

.....

.....

.....

.....
/ нэр, гарын үсэг /

.....
/ нэр, гарын үсэг /

....oOo....